



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/269

Чингис хот

Зохион байгуулалтын зарим  
арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Засгийн газрын 2020 оны 62, 64, 102 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн №22 дугаар хурлын шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн №23 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр хандивласан бог малыг худалдан борлуулах ажлын хэсгийг 1 дүгээр хавсралт, коронавируст халдвартай тэмцэх хариу арга хэмжээний багийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Бие бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлыг хангуулж, заавар зөвлөмжөөр хангахыг ажлын хэсгийн ахлагч, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Хандивын бог мал худалдан борлуулах ажлын хэсэг

Ажлын хэсгийн ахлагч:	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа
Гишүүд:	Ж.Энх-Амгалан Н.Анхбаяр	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Мал эмнэлэгийн газрын дарга Сумдын Засаг дарга нар

Шинэкоронавируст халдварт цар тахалтай  
тэмцэх хариу арга хэмжээний баг

- Багийн ахлагч: Аймгийн Засаг даргын орлогч
- Нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн газрын дарга
- Гишүүд:
- Гамшгаас хамгаалах албадын дарга нар
  - Эрүүл мэндийн алба-Эрүүл мэндийн газар
  - Хүнс хөдөө аж ахуйн алба-Хүнс, хөдөө аж ахуйн газар
  - Түлш эрчим хүчний алба-Цахилгаан түгээх сүлжээ салбар
  - Хэв журам сахиулах алба-Цагдаагийн газар
  - Сурталчилгааны алба-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
  - Мэдээлэл харилцаа холбооны алба-Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК
  - Зам тээврийн алба-Авто тээврийн үндэсний төвийн Хэнтий аймаг дахь салбар
  - Байгалийн болон химийн аюулыг үнэлж мэдээлэх алба-Ус, цаг уур, орчны шинжилгээний алба
  - Барилга хот байгуулалтын алба-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
  - Мэргэжлийн хяналтын алба-Мэргэжлийн хяналтын газар
  - Хүн ам, нийгмийн хамгааллын алба-Нийгмийн бодлогын хэлтэс